


МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАМГААЛАХ ЗӨВЛӨМЖҮҮД

Цахим орчин дахь халдлагаас өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?



Олон нийтийн сүлжээний сайтуудад нэгдэхээсээ өмнө сайтар шалгаж нягтлах.



Хувийн мэдээллээ олон нийтийн сүлжээнд аль болох байршуулахгүй байх.



Үл мэдэгдэх эх сурвалжаас ирсэн цахим шуудангийн хавсралт, холбоосуудыг нээхгүй байх.




Төлбөргүй, хамгаалалтгүй утасгүй интернэт (WiFi) нь таны хувийн мэдээллийг хулгайлах гол хэрэгсэл болдог тул холбогдохоос зайлсхийх;



Зар сурталчилгааны хуудаснуудаар дамжуулан хувийн болон санхүүгийн мэдээллийг асуух нь луйврын шинжтэй байдаг тул тэдгээрт та ач холбогдол өгөлгүй шууд хааж байх.



Хувийн болон санхүүгийн мэдээлэл асуусан, лавласан мессежинд хариу өгөхгүй байх. Мессеж явуулсан дугаарыг хянан батлах.



Нууц үгийн найдвартай давтагдашгүй цорын ганц байдлыг хангах, тогтмол солих. Хувийн и-мэйл хаяг, систем бүрд өөр нууц үг ашиглах.



Үг үсгийн алдаа болон бусад төрлийн алдаа нь ихэвчлэн цахим шуудан болон вэб хуудасны луйврын нэг илрэл байдаг. Үг үсгийн болон дүрмийн алдаа, өвөрмөц бичиглэл, найруулгын алдаанаас та болгоомжлоорой.



Өөрийн цахим хаяг болон төхөөрөмжүүдэд нэвтрэхдээ давхар баталгаажуулалтын /2FA/ аргыг ашиглах. (өөр и-мэйл болон мессежээр баталгаажуулах).



Цахим орчинд төлбөр хийх тохиолдолд тухайн вэбсайтын баталгаатай эсэхийг шалгах.